

UCS1203B:2022

# ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ГАДНА ОРЧИН




Амралтын газар, жуулчны баазын гадна болон  
дотоод орчны тохижилт, зохион байгуулалтад  
тавих ерөнхий шаардлага



# ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ГАДНА ОРЧИН

Амралтын газар, жуулчны баазын гадна болон дотоод  
орчны тохижилт, зохион байгуулалтад тавих  
ерөнхий шаардлага

*Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 22-р тогтоолоор батлав.*



## ГАРЧИГ

1. Хамрах хүрээ .....	5
2. Норматив эшлэл.....	5
3. Нэр томъёоны тодорхойлолт.....	6
4. Төлөвлөлтийн ерөнхий шаардлага.....	6
5. Тохижилт, нийтийн орон зайд тавигдах шаардлага .....	7
6. Үйлчилгээний ерөнхий шаардлага .....	14
7. Зочин байрлуулах байранд тавигдах шаардлага.....	16
8. Хоолны газарт тавигдах шаардлага.....	18
9. Нийтийн ариун цэврийн байгууламжид тавигдах шаардлага .....	19
10. Угаалгын газар тавигдах шаардлага.....	20
11. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах, түр хадгалахад тавигдах шаардлага .....	21
12. Галын аюулгүй байдлыг хангах.....	24
13. Мэдээллийн самбар, анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ .....	25
14. Бохир усны инженерийн байгууламж, цэвэрлэсэн бохир усанд тавигдах стандарт шаардлага.....	27
15. Үйлчилгээний ажилтан, ажлын байранд тавигдах шаардлага.....	27
16. Шалгуур үзүүлэлт .....	29

### ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Амралтын газар, жуулчны баазын ерөнхий төлөвлөлт /жишээ зураг/.....	6
Зураг 2. Амралтын газар, жуулчны баазын ерөнхий төлөвлөлт харагдах байдал /жишээ зураг/ .....	7
Зураг 3. Амралтын газар, жуулчны баазын тээврийн хэрэгслийн ил зогсоолын төлөвлөлт /жишээ зураг/.....	8
Зураг 4. Амралтын газар, жуулчны бааз тээврийн хэрэгслийн ил зогсоолын харагдах байдал /жишээ зураг/.....	8
Зураг 5. Амралтын газар, жуулчны бааз тээврийн хэрэгслийн ил зогсоолын харагдах байдал /жишээ зураг/.....	8
Зураг 6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тээврийн хэрэгслийн зогсоолын харагдах байдал /жишээ зураг/.....	9
Зураг 7. Хүүхдийн тоглоомын талбай /жишээ зураг/ .....	10
Зураг 8. Спорт талбай /жишээ зураг/ .....	10
Зураг 9. Сагсан бөмбөгийн талбай /жишээ зураг/.....	11
Зураг 22. Дагуу налуу, хөндлөн хэвгий /Жишээ зураг/ .....	13
Зураг 23. Гэрэлтүүлэг хоорондын зай болон гэрлийг суурилуулах.....	13
Зураг 24. Амралтын газар, жуулчны баазын зам талбайн гэрэлтүүлэг /жишээ зураг/.....	14
Зураг 25. Ногоон байгууламж /жишээ зураг/ .....	14
Зураг 26. Зочид хүлээн авах хэсэг /жишээ зураг/ .....	15
Зураг 27. Зочдын хүлээлгийн хэсэг /жишээ зураг/ .....	15
Зураг 28. Хяналтын камерын дэлгэц /жишээ зураг/.....	16



Зураг 29. Зочин байрлах байр /жишээ зураг/ .....	17
Зураг 30. Хоол үйлдвэрлэлтийн заалны урсгал дараалал /жишээ зураг/.....	18
Зураг 31. Хүнсний аюулгүй байдлыг хангах /жишээ зураг/ .....	18
Зураг 32. Нийтийн бие засах газар /жишээ зураг/.....	19
Зураг 33. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан ариун цэврийн өрөө /жишээ зураг/ .....	20
Зураг 34. Угаалгын өрөөний технологийн урсгал /жишээ зураг/.....	21
Зураг 35. Хог ангилан ялгах хэсэг /жишээ зураг/ .....	22
Зураг 36. Хог ангилан ялгах хогийн сав /жишээ зураг/ .....	22
Зураг 42. Хогийн сав /жишээ зураг/.....	24
Зураг 43. Галын хорыг нүдэнд харагдахуйц газар байрлуулна /жишээ зураг/ .....	24
Зураг 44. Галын аюулаас сэргийлэх булан. /Жишээ зураг/.....	25

### **ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. Хашаа, хайс, хашлаганы төрлүүд .....	11
Хүснэгт 2. Зочны өрөөний орны тоо, талбайн харьцаа .....	17
Хүснэгт 3. Хог ангилан ялгах хогийн сав.....	23
Хүснэгт 4. Мэдээллийн самбар болон анхааруулах тэмдэг /жишээ зурагтай/.....	26



**НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

□ Худалдаа, үйлчилгээний газрын гадна □  
орчинд хамаарах хотын стандартыг батлах  
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10<sup>1</sup> дүгээр зүйлийн 10<sup>1</sup>.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн Худалдаа, үйлчилгээний газрын гадна орчин бүлэгт хамаарах дор дурдсан стандартуудыг хавсралтаар баталсугай. Үүнд:

1.1. UCS1201B:2022 “Худалдаа, үйлчилгээний газрын гадна орчны ерөнхий шаардлага” хотын стандарт

1.2. UCS 1202B:2022 “Худалдаа, үйлчилгээний газрын гадна сурталчилгааны байгууламжид тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.3. UCS1203B:2022 “Амралтын газар, жуулчны баазын гадна болон дотоод орчны тохижилт, зохион байгуулалтад тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

2. Батлагдсан хотын стандартуудыг мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

ДАРГА



Ж. БАТБАЯСГАЛАН

1110100310



Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 22  
дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

## ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ГАДНА ОРЧИН

### UCS 1203B:2022 “АМРАЛТЫН ГАЗАР, ЖУУЛЧНЫ БААЗЫН ГАДНА БОЛОН ДОТООД ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА” ХОТЫН СТАНДАРТ

#### 1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандарт нь нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа амралтын газар, жуулчны баазын гадна болон дотоод орчинд тавих ерөнхий шаардлагыг тогтооно.

#### 2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандарт нь эш татсан дараах хууль, барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг бүрэн хангах бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- MNS 6043:2019. Амралтын газар, жуулчны баазад тавих ерөнхий шаардлага;
- MNS 6426:2013. Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц. Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага;
- MNS 5682: 2006 Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам. Техникийн шаардлага;
- MNS 6808:2019 Явган хүний зам, талбайн төлөвлөлт. Техникийн шаардлага;
- MNS 3736: 2010 Хамгаалалтын төмөр бетон хашаа. Техникийн шаардлага;
- MNS 5828: 2008 Угсармал төмөр бетон хашаа. Техникийн шаардлага;
- MNS 6751: 2019 Хүүхдийн тоглоомын талбай. Ерөнхий шаардлага;
- MNS 5344: 2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага;
- MNS 4943:2011. Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага;
- MNS 4288:1995. Бохир ус цэвэрлэх байгууламжуудын байршил, цэвэрлэгээний технологи түвшинд тавих үндсэн шаардлага;
- MNS5566:2005. Галын аюулаас хамгаалах аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм;
- БНБД 40-01-06. Ариутгах татуурга, гадна сүлжээ ба байгууламж;
- MNS BS 8525-1:2015. Саарал усны систем ерөнхий шаардлага;
- MNS 4946:2019. Хоолны газрын ангилал, зэрэглэл. Үндсэн шаардлага;
- MNS 4244:1994. Галын аюулгүй байдал;
- MNS 0900:2005. Хүрээлэн буй орчин, эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдал, Ундны ус, эрүүл ахуйн шаардлага түүнд тавих хяналт;
- MNS 5924:2015. Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага;
- MNS6423:2019. Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага;
- БНБД 41-01-11. Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер;
- UCS 1401B:2022. Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө: Хашаа, хайс, хашлаганд тавих ерөнхий шаардлага;
- UCS 1901B:2022. Гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэл: Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд байршуулах гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавих шаардлага;

- UCS 1405B:2022. Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө: Хүүхдийн, тоглоомын талбайн ерөнхий шаардлага;
- UCS 0902B:2020. Иж бүрэн гудамж: Гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага;
- UCS 1406B:2022. Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө: Нийтийн эзэмшлийн зам талбайн хогийн саванд тавих шаардлага;
- UCS 0901B:2020. Иж бүрэн гудамж: Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих шаардлага;


### 3. НЭР ТОМЬЁНЫ ТОДОРХОЙЛОЛТ

**Амралтын газар:** Тав тухтай амрах нөхцөлийг бүрдүүлсэн байршуулах, хоол, ундны болон нэмэлт үйлчилгээ үзүүлэх үйлчилгээний байгууллага;

**Жуулчны бааз:** Байгаль, түүх, соёлын нөөцөд түшиглэсэн, байршуулах, хоол, ундны болон нэмэлт үйлчилгээ үзүүлэх жуулчны үйлчилгээний байгууллага.

### 4. ТӨЛӨВЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

4.1. Амралтын газар, жуулчны баазыг төлөвлөхдөө зочин байрлуулах байр, чөлөөт цаг өнгөрөөх амралт, үзвэрийн бүс, тоглоомын болон спорт талбай, хоолны газар, угаалга, тээврийн хэрэгслийн зогсоол, хог хаягдал түр хадгалах цэг, ариун цэврийн байгууламж болон бусад шаардлагатай барилга байгууламжийг амралтын газар, жуулчны баазын хэмжээ, үйлчилгээний төрөл, цар хүрээнд тохируулан стандарт, орчны аюулгүй байдлын шаардлагыг хангуулан төлөвлөнө. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хүлээн авах, үйлчлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.



Зураг 1. Амралтын газар, жуулчны баазын ерөнхий төлөвлөлт (Жишээ зураг)

- 4.2. Амралтын газар, жуулчны бааз байгуулахдаа газрын байршлыг усан сан бүхий газар буюу гол, нуур, ойн сан бүхий газраас 200 м-ээс дээш зайд төлөвлөнө.
- 4.3. Төв замаас амралтын газар хүрэх зам нь ямар нэг бартаа саадгүй тодорхой байх бөгөөд амралтын газар, жуулчны бааз хүртэлх чиглэл заасан тэмдгийг “Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хаших, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм” MNS4596:2014 стандартад заасны дагуу өдөр, шөнийн аль ч цагт харагдахуйц байршуулна.
- 4.4. Амралтын газар, аялал жуулчлалын баазын дотоод зорчих хөдөлгөөний схем зурагтай байна.





Зураг 2. Амралтын газар, жуулчны баазын ерөнхий төлөвлөлт харагдах байдал (Жишээ зураг)

## 5. ТОХИЖИЛТ, НИЙТИЙН ОРОН ЗАЙД ТАВИХ ШААРДЛАГА


- 5.1. Амралтын газар, жуулчны баазад амралтын бүс, үзвэрийн талбай, тоглоомын талбай, спорт талбай, ногоон байгууламжийг төлөвлөж үйлчлүүлэгчийн тав тух, аюулгүй байдлыг ханган тохижуулна.
- 5.2. Амралтын газар, жуулчны баазын нэрийн самбар, байгууламжид оноосон нэрийг тодорхой, ойлгомжтой дүрсэлж, амралтын газар, жуулчны баазын үйл ажиллагааны онцлогийг илэрхийлсэн дизайнтай өдөр болон шөнийн аль ч цагт танигдахаар гол хаалганы дэргэд байрлуулан тохижуулна.
- 5.3. Гадна тохижилт нь амралтын газар, жуулчны баазын онцлогийг илэрхийлсэн цэвэр цэмцгэр, өнгө үзэмжтэй, чанар, стандартын шаардлага хангасан, эдэлгээ даах материалаар хийгдсэн байна.
- 5.4. Гадна тохижилтын засвар үйлчилгээг тодорхой хугацаанд тогтмол хийж хэвшсэн байна (Будах, засах, солих, шинээр тохижуулах гэх мэт).

### Тээврийн хэрэгслийн зогсоол

- 5.5. Гадна хаалгаар нэвтрэн ороход үйлчлүүлэгчдэд эрсдэл саад учруулахгүй, тусгай зориулалт бүхий талбайд машины зогсоолыг төлөвлөж, зохих тэмдэг, тэмдэглэгээ байрлуулсан байна.
- 5.6. Тээврийн хэрэгслийн зогсоолыг төлөвлөж байгуулахдаа Иж бүрэн гудамж: “Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавих ерөнхий шаардлага” UCS 0902B:2022-г баримтална.



Зураг 3. Амралтын газар, жуулчны баазын тээврийн хэрэгслийн ил зогсоолын төлөвлөлт (Жишээ зураг)




Зураг 4. Амралтын газар, жуулчны баазын тээврийн хэрэгслийн ил зогсоолын харагдах байдал (Жишээ зураг)



Зураг 5. Амралтын газар, жуулчны баазын тээврийн хэрэгслийн ил зогсоолын харагдах байдал (Жишээ зураг)





Зураг 6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тээврийн хэрэгслийн зогсоолын харагдах байдал (Жишээ зураг)

## Амралтын бүс

- 5.7. Амралтын бүсэд архитектур болон ландшафтын жижиг элемент болох цэцэрлэгт хүрээлэн, шаардлагатай зам талбай, усан толио, баримал, сүүдрэвч, гэрэлтүүлэг, хогийн сав гэх зэрэг элементүүдийг ашиглаж болно. Хийцийн хувьд хүний биеийн дундаж хэмжээст таарсан байх бөгөөд ахмад настан, хүүхдэд зориулсан аюулгүй байдлыг хангасан материал, элементүүдийг сонгож авна.
- 5.8. Эдгээрийг байршуулахдаа сүүдрэвч, баримал, энгийн тавьсан байгалийн чулуу, тэдний өнгө, фактур, фон зэргийг зайлшгүй харгалзан үзэхээс гадна дэвсгэр өнгө болон орчны тохижилт зам талбайтай уялдуулан байршуулна.
- 5.9. Амралтын бүсэд сандал, саравч, сүүдрэвчийг “UCS1404B:2022 Саравч,сүүдрэвчинд тавих ерөнхий шаардлага”, “UCS1407B:2022 Нийтийн эзэмшлийн зам талбайн сандалд тавих ерөнхий шаардлага” стандартын дагуу байрлуулна.

## Тоглоомын талбай

- 5.10. Хүүхдийн тоглоомын талбайн тохижилт нь Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага UCS1405B:2022 стандартыг хангасан байна.
- 5.11. Хүүхдийн тоглоомын тоног хэрэгслүүд нь хүүхдэд аюул учруулахгүй, бэртэж гэмтэхээс сэргийлсэн зориулалтын материалаар хийгдсэн байна. Хүүхдийн тоглоомын талбайг насны ангиллаар тохижуулж санамж байршуулна.






Зураг 7. Хүүхдийн тоглоомын талбай (Жишээ зураг)

### Спорт талбай

- 5.12. Амралтын газар жуулчны бааз нь үйл ажиллагааны онцлогт тохируулан спортын талбайг тохижуулсан байна. Спортын талбайн тохижилт, тоног төхөөрөмж, материал зэрэг нь холбогдох стандартын шаардлага хангасан, цэвэр, өнгө үзэмжтэй, бүх насны хүн үйлчлүүлж болохуйц байна.
- 5.13. Сагсан бөмбөгийн талбайн самбар тогтоох шон, гар бөмбөгийн талбайн торыг тогтоох шонг газарт хөдөлгөөнгүй 0,8 м-ээс багагүй гүнд суулган шонгийн гадаргууг зөөлөвч материалаар бүрж үйлчлүүлэгчдийг аюул осолд өртөхөөс сэргийлсэн байна.
- 5.14. Аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тоног төхөөрөмжийн заавар, тэмдэг, тэмдэглэгээг нүдэнд харагдах газар байрлуулна.



Зураг 8. Спорт талбай (Жишээ зураг)




Зураг 9. Сагсан бөмбөгийн талбай (Жишээ зураг)


### Хашаа, хайс, хашлага

5.15. Гадна талбайн хашаа хайс нь Хашаа хайс, хашлагад тавигдах ерөнхий шаардлага, хэрэглээ UCS0001-02:2019 стандартад заагдсаны дагуу нэгэн жигд төмөр торон зэврэлтээс хамгаалсан гадаргуутай, зөөж угсрахад хялбар, байгаль, цаг уурын эрс тэс нөхцөлд тэсвэртэй, өнгө үзэмж алдаагүй, эвдэрч гэмтээгүй байна.

#### Хүснэгт 1. Хашаа, хайс, хашлаганы төрлүүд

Хашааны төрлүүд	
 <p>Зураг 10. (Жишээ зураг)</p>	 <p>Зураг 11. (Жишээ зураг)</p>
 <p>Зураг 12. (Жишээ зураг)</p>	 <p>Зураг 13. (Жишээ зураг)</p>






Зураг 14. (Жишээ зураг)



Зураг 15. (Жишээ зураг)




Зураг 16. (Жишээ зураг)




Зураг 17. (Жишээ зураг)



Зураг 18. (Жишээ зураг)



Зураг 19. (Жишээ зураг)



Зураг 20. (Жишээ зураг)




Зураг 21. (Жишээ зураг)

### Явган хүний зам

5.16. Амралтын газар, жуулчны баазын явган хүний замыг төлөвлөхдөө Иж бүрэн гудамж: “Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих шаардлага” UCS 0901B:2022 стандартыг баримтална.

5.17. Амралтын газар, жуулчны баазын явган хүний замын төлөвлөлтөд тавих нэмэлт шаардлага Үүнд:

- явган хүний замын гадаргууг тэгшилж тэгш хэмтэй болгоно;
- явган хүний зам, ногоон байгууламжийг тусгаарласан хашлагатай байна;
- явган хүний замын өргөн 1.5 метрээс доошгүй өргөнтэй байна;
- явган хүний замыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэн зохион байгуулсан байна;
- явган хүний замын уулзвар хэсэгт амралтын газрын схем зураг болон үйлчилгээний байрын чиглэлийг заасан тэмдэг байрлуулна.




Зураг 22. Дагуу налуу, хөндлөн хэвгий (Жишээ зураг)

## Гэрэлтүүлэг

5.18. Нийтийн талбайн гэрэлтүүлэг нь тухайн амралтын газар, жуулчны баазын гадна, дотоод орчныг бүхэлд нь гэрэлтүүлэх боломжтой “Гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” UCS1901B:2022 стандартын шаардлагыг хангасан байна.


5.19. Амралтын газар, жуулчны баазын гэрэлтүүлэгт тавих нэмэлт шаардлагыг тодорхойлов. Үүнд:

- төв гэрэлтүүлгийг орох, гарах хаалга, хашаа болон хайсны 4 талд байрлуулна;
- гэр, байшин, ресторан, нийтийн ариун цэврийн өрөө, халуун ус, гарах хаалга хүртэлх замын дагуу жижиг гэрэлтүүлгээр хангасан байна;
- явган хүний зам дагуух гэрэлтүүлэг нь тусгалын хүчин чадлаас хамааран хоорондын зайг 8 м-ээс багагүй байхаар тооцон байршуулна;
- байгальд ээлтэй байдлаар нарны энерги, салхины эрчим хүчээр цэнэглэгдэх гэрэлтүүлэг хэрэглэж болно.



Зураг 23. Гэрэлтүүлэг хоорондын зай болон гэрлийг суурилуулах





Зураг 24. Амралтын газар, жуулчны баазын зам талбайн гэрэлтүүлэг (Жишээ зураг)

### Ногоон байгууламж

5.20. Амралтын газар, жуулчны баазын ногоон байгууламжийг төлөвлөхдөө цаг уур, хөрсний шинж чанараас хамааруулж зүлэг, цэцэг мод, бут, сөөгийг сонгон тариална. Мод, бут, сөөгийг сонгохдоо өргөсгүй, элдэв хурц үнэргүйг сонгоно.



Зураг 25. Ногоон байгууламж (Жишээ зураг)

## 6. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

6.1. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа амралтын газар, жуулчны бааз нь MNS 6043:2019 “Амралтын газар, жуулчны баазад тавих ерөнхий шаардлага” MNS 6043:2019 стандартыг хангаж үйлчилгээ үзүүлнэ.

### Зочин хүлээн авах, бүртгэх үйл ажиллагаа

6.2. Зочин хүлээн авах хэсэг нь зориулалтын тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан ажлын байртай, зочин хүлээн авч бүртгэх, үдэх үйлчилгээг үзүүлнэ.

6.3. Үйлчилгээний ажилтан нь цэвэр цэмцгэр хувцастай, эелдэг боловсон харилцаатай байна.

6.4. Амралтын газар, жуулчны баазын менежер болон зочин угтагч нь гадаад хэлийг дундаас дээш түвшинд эзэмшсэн, бусад ажилчид нь гадаад хэлний зохих мэдлэгтэй байна.



6.5. Зочныг бүртгэхдээ зөвхөн бичиг баримттай иргэдийг бүртгэн үйлчилгээ үзүүлнэ. Аливаа эрсдэл үүсэхээс сэргийлж үйлчилгээ авсан иргэдийн бичиг баримтыг хуулбарлан авсан байна. Мөн зочдыг хүлээн авах хэсэгт үйлчлүүлэгчдэд харагдах байдлаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль сурталчилсан самбар, мэдээлэл байршуулсан байна.



*Зураг 26. Зочид хүлээн авах хэсэг (Жишээ зураг)*

6.6. Зочин хүлээн авах хэсэг нь зочны хүлээлгийн танхимтай үйлчлүүлэгчдийн тав тухыг хангасан, тохижуулсан хэсэгтэй /сонголтоор буйдан, сандал, ширээ/ байна. Үйлчилгээний талаар мэдээлэл, үнэ зэргийг Монгол, Англи хэлээр бичсэн танилцуулгын материалыг байрлуулсан байна.



*Зураг 27. Зочдын хүлээлгийн хэсэг (Жишээ зураг)*

## Тээвэр

6.7. Гадаад, дотоодын зочдын санал хүсэлтийг үндэслэн автобус, такси, галт тэрэг, онгоцны билет захиалах, машин түрээслэх боломжийг бүрдүүлсэн байна.

## Харуул хамгаалалт

6.8. Зочдын аюулгүй байдлыг хангах харуул хамгаалалтын арга хэмжээг 24 цагийн турш хэрэгжүүлнэ. Үүнд: амралтыг газар, жуулчны баазын орох, гарах хэсэгт харуултай байх, нэгдсэн хяналтын камертай байх гэх мэт.

6.9. Амралтын газар, жуулчны баазын барилга байгууламж, гэр болон бусад нийтийн зориулалттай газарт зочны аюулгүй байдлыг хангах “Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага” MNS6423:2019 стандартад нийцсэн хяналтын камер байрлуулан дэлгэцийн хяналтыг хамгаалагч, зочин хүлээн авах хэсэгт байрлуулж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.



Зураг 28. Хяналтын камерын дэлгэц (Жишээ зураг)

## Төлбөр тооцоо

6.1. Төлбөр тооцоог бэлэн болон бэлэн бусаар хийх боломжийг бүрдүүлсэн байна.

## 7. ЗОЧИН БАЙРЛУУЛАХ БАЙРАНД ТАВИХ ШААРДЛАГА

7.1. Зочин байрлуулах байр нь MNS 6043:2019 “Амралтын газар, жуулчны баазад тавих ерөнхий шаардлага” стандартад заасан зочны өрөө, гэрт тавих шаардлагын /А хавсралт/ хангасан байна.

7.2. Зочид байрлах өрөөнд цагдаа, онцгой, эрүүл мэндийн байгууллагын тусламж мэдээллийн утасны дугаарыг ил харагдах газар Монгол, Англи хэл дээр бичиж байрлуулна.



*Хүснэгт 2. Зочны өрөөний орны тоо, талбайн харьцаа*

Орны тоо	Талбайн хэмжээ
1 ортой өрөө	15м <sup>2</sup> -аас багагүй
2 ортой өрөө	18м <sup>2</sup> -аас багагүй
3 ортой өрөө	20м <sup>2</sup> -аас багагүй
4 ортой өрөө	24м <sup>2</sup> -аас багагүй

- 7.3. Өрөө, гэрт зочны тоогоор хувцасны өлгүүр, мөр өлгүүр болон зориулалтын цагаан хэрэгсэл, орны бүтээлэг, дэр, сандал, ширээ, гутлын шүүгээ, орны дэргэд шургуулгатай шүүгээ, толь, гарын алчуур, угаалтуур, ариун цэврийн хэрэгсэл/оо, сойз, бэлгэвч/ зэрэг тохижилттой байна.
- 7.4. Зочны байр нь тэгш хэмтэй, өнгө үзэмжтэй, зориулалтын шалтай байна.
- 7.5. Зочин байрлуулах байр нь үйлчилгээний ажилтантай холбогдох хонх, дотуур холбоо, агааржуулагч, халаагуур, зуух гэх мэт тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байх бөгөөд ашиглалтын заавар, үйлчилгээний ажилтантай холбогдох утасны дугаарыг үйлчлүүлэгчид харагдахаар байршуулсан байна.
- 7.6. Амралтын газар, жуулчны баазаас үзүүлдэг урлаг соёлын үзвэр, амралт, эрүүл мэндийн үйлчилгээ, хоол ундааны төрөл, үнийн талаар мэдээллийг Монгол, Англи хэлээр бэлтгэн зочны байр бүрд байрлуулна.



*Зураг 29. Зочин байрлах байр (Жишээ зураг)*


- 7.7. Халаалтын шийдэл нь гэр, байшин, өрөөг цахилгаанаар халдаг байхаар зохицуулж төлөвлөнө. Нам даралтын зуухаар халаадаг бол галын аюулгүй байдлыг хангаж “Галын аюулгүй байдлын ерөнхий шаардлага” MNS4244:1994 Галын аюулгүй байдлын ерөнхий шаардлага стандартыг мөрдөн ажиллана.

- Зочны байрлах гэр болон байшинг ердийн галлагааны зуухаар халаадаг бол яндан, зуухны бүрэн бүтэн байдлыг шалгаж, угаар мэдрэгч дохиоллын төхөөрөмжийг байршуулан болзошгүй аюулаас урьдчилан сэргийлсэн байна.

- Зуухнаас үнс, гал унахаас сэргийлж, шатдаггүй материал ашиглан суурь бэлтгэж байрлуулсан байна.

## 8. ХООЛНЫ ГАЗАРТ ТАВИХ ШААРДЛАГА

- 8.1. Хоолны газар нь “Хоолны газрын ангилал зэрэглэл үндсэн шаардлага” MNS4946:2019 стандартыг хангасан байна.
- 8.2. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологи, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангаж хоолны дээж аван 72 цаг хадгална. Техник, тоног төхөөрөмжтэй харьцах, хөдөлмөр аюулгүй ажиллагааны зааварчилгаагаар ажилчдыг ханган, зохих журмын дагуу бүртгэл хөтөлдөг байна.



Зураг 30. Хоол үйлдвэрлэлтийн заалны урсгал дараалал (Жишээ зураг)

## ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ 5 ЗАРЧИМ

1	2	3	4	5
<b>ЭРҮҮЛ, ЦЭВЭР БАЙХ</b>	<b>ЗОХИХ ХЭМД ЗӨВ ХАДГАЛАХ</b>	<b>ХӨНДЛӨНГИЙН БОХИРДЛООС СЭРГИЙЛЭХ</b>	<b>УГААХ, ЗАЙЛАХ, АРИУТГАХ</b>	<b>ГҮЙЦЭД ЧАНАХ, ЗӨВ ХӨРГӨХ</b>
<p>Гараа бохирдох бүрт сайтар савацдаж угаана</p> <p>Өвдсөн үедээ хоол бэлтгэх ажиллагаанд оролцохгүй</p> <p>Шууд хэрэглэх бүтээгдэхүүнийг бохир гараар барихгүй</p>	<p>Хүйтнээр нь байлгах хоол, хүнсний 5°C ба түүнээс бага хэмд хадгална</p> <p>Халуунаар нь байлгах хоол, хүнсний 60°C ба түүнээс дээш хэмд хадгална</p>	<p>Түүхий хүнсний бүтээгдэхүүнийг жимс, талх зэрэг шууд идэх мөн чанаж болгосон хоол, хүнстэй хамт хадгалахгүй</p> <p>Түүхий бүтээгдэхүүнд хэрэглэх гампанз, тавиур мод, хутга, заавуур, сав, суулгыг шууд идэх хүнсэнд хэрэглэхгүй</p>	<p>1. Зориулалтын шингэнээр сайтар угааж, цэвэрлэх</p> <p>2. Цэвэр усаар зайлах</p> <p>3. Ариутгах</p> <p>Хоолны хэрэгсэл, сав суулга, тоног төхөөрөмжийг байнга угааж цэвэрлэн ариутгана</p>	<p>Хоол, хүнсийг гүйцэд чанаж болгоно</p> <p>Чанаж болгосон хоолны гүний хэм 70°C ба түүнээс дээш байна</p>

Зураг 31. Хүнсний аюулгүй байдлыг хангах (Жишээ зураг)



- Хүүхдийн болон цагаан хоолны сонголттой байна.
- Өглөөний цайны үйлчилгээтэй, олон төрлийн сонголттой байна.
- Хүргэлтийн болон захиалгат, үйлчилгээтэй байна.


## 9. НИЙТИЙН АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИД ТАВИХ ШААРДЛАГА

- 9.1. Нийтийн ариун цэврийн байгууламжийг төлөвлөхдөө ариун цэвэр, эрүүл ахуйн аюулгүй байдал, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй байдлыг хангаж төлөвлөж байгуулна.
- 9.2. Нийтийн бие засах газрын эрэгтэй, эмэгтэй өрөө тусдаа байна.
- 9.3. Эрэгтэй, эмэгтэй өрөөг ялгах таних тэмдгийг хаалган дээр зочдод харагдахаар байрлуулж, бүрэн бүтэн ашиглалтын шаардлага хангасан суултуур, угаалтуур, толь, гар хатаах хэрэгсэл, гарын шингэн саван, хогийн сав, ариун цэврийн цаасны тавиур, цаас зэргээр хангагдсан байна.
- 9.4. Нийтийн бие засах өрөөний ханыг ус, чийг, галд тэсвэртэй, цэвэрлэхэд хялбар материалаар хийнэ.
- 9.5. Ариун цэврийн байгууламжийн цэвэр, бохир ус, дулааны шугам хоолойн угсралт нь БНБД40-60-16 “Дотор сан техникийн систем”-ийн шаардлагад нийцсэн байна.
- 9.6. Нийтийн усанд орох газар нь эрэгтэй, эмэгтэй өрөө тусдаа байна.
- 9.7. Эрэгтэй, эмэгтэй өрөөг ялгах таних тэмдэгтэй байх бөгөөд нүдэнд ил харагдахуйц газарт байрлуулж, өдөр шөнийн аль ч цагт танигдахуйц байна.
- 9.8. Халуун хүйтэн устай, ашиглалтын шаардлага хангасан цоож, бариултай, шүршүүр усанд ороход зориулсан хэрэгсэлтэй, сандал, хувцасны өлгүүр, хувцас солих хэсэгтэй, халтирахаас хамгаалсан шалавч, ослын бариултай байна.
- 9.9. Усны өрөөний ханыг ус, чийг, галд тэсвэртэй, цэвэрлэхэд хялбар материалаар хийнэ.



Зураг 32. Нийтийн бие засах газар (Жишээ зураг)

9.10. Ариун цэврийн байгууламжийн цэвэр, бохир ус, дулааны шугам хоолойн угсралт нь БНБД40-60-16“ Дотор сан техникийн систем”-ийн шаардлагад нийцсэн байна.



Зураг 33. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан ариун цэврийн өрөө (Жишээ зураг)

9.11. Нийтийн бие засах газрын суултуур, угаалтуур, шүршүүрийг нийт үйлчилгээний хүчин чадлын 10 хувьтай тэнцэхээр тооцон төлөвлөж, “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцон орон зай орчин” MNS 6055:2009 үндсэн шаардлагыг ханган хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тоноглол суурилуулсан байна.

9.12. Байгаль орчинд сөргөөр нөлөөлөхүйц шаардлага хангахгүй, хөрс бохирдуулагч нүхэн жорлон ашиглахыг хориглоно.

## 10. УГААЛГЫН ГАЗАР ТАВИХ ШААРДЛАГА

10.1. Угаалгын хэсэг нь тусгай тохижуулсан, агааржуулалт сайтай өрөөтэй байна.


10.2. Угаалгын хэсгийн урсгал, дарааллыг зөв бүрдүүлж, цэвэр цагаан хэрэглэл хадгалах өрөөг тусад нь тохижуулна.

10.3. Техник тоног төхөөрөмж ашиглах аюулгүй ажиллагааны зааварчилгааг нүдэнд ил харагдахаар холбогдох төхөөрөмжийн дэргэд байрлуулна.

10.4. Зориулалтын индүүдэх үйлчилгээний хэсэгтэй байна.

10.5. Угаалгын өрөөнд баримтлах дүрэм:

- өдөр тутмын ариутгал, их цэвэрлэгээг хуваарийн дагуу хийж гүйцэтгэнэ;
- угаалгын өрөөнд тухайн хэсгийн ажилтнаас өөр хүн гаднаас нэвтэрч орохыг хориглоно;
- эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэм баримтлан ажиллана;
- нэвтрэх хэсэгт нөмрөг, улавч зэргийг байрлуулна.



Зураг 34. Угаалгын өрөөний технологийн урсгал (Жишээ зураг)


## 11. ХОГ ХАЯГДЛЫГ ЭХ ҮҮСВЭР ДЭЭР НЬ АНГИЛАХ, ТҮР ХАДГАЛАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 11.1. Үйл ажиллагаанаас гарсан хог хаягдлаа эх үүсвэр дээр нь ангилан ялгах /дахивар, энгийн/ түр хадгалах цэгтэй байх бөгөөд тус цэг нь хог хаягдал гадагшлах, салхиар тарахаас хамгаалсан битүү тагтай, хөрс бохирдуулахаас хамгаалсан үл нэвтрүүлэгч суурьтай байна.
- 11.2. Хог хаягдлын түр хадгалах цэгийг зочны байр, барилга байгууламжаас 60м-ээс багагүй зайд, салхины урсгалын доод чигт байрлуулж байгалийн салхинд хийсэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.





Зураг 35. Хог ангилан ялгах хэсэг (Жишээ зураг)



Зураг 36. Хог ангилан ялгах хогийн сав (Жишээ зураг)

## Хүснэгт 3. Хог ангилан ялгах хогийн сав

 <p>ШИЛ, ЛААЗ GLASS &amp; CANS</p> <p>Зураг 37. (Жишээ зураг)</p>	Шил, Лааз ангилан ялгах хогийн сав
 <p>ХУВАНЦАР, ГЯЛГАР УУТ PLASTIC</p> <p>Зураг 38. (Жишээ зураг)</p>	Хуванцар, гялгар уут ангилан ялгах хогийн сав
 <p>ХҮНС FOOD</p> <p>Зураг 39. (Жишээ зураг)</p>	Хоол хүнс ангилан ялгах хогийн сав
 <p>ЦААС PAPER</p> <p>Зураг 40. (Жишээ зураг)</p>	Цаас ангилан ялгах хогийн сав
 <p>БУСАД ХОГ NON RECYCLABLE</p> <p>Зураг 41. (Жишээ зураг)</p>	Бусад хог хаягдлыг ангилан ялгах хогийн сав

11.3. Дөрвөн байшин, дөрвөн гэрийн дунд нэгээс багагүй хогийн сав байхаар тооцон байршуулна.





Зураг 42. Хогийн сав (Жишээ зураг)

## 12. ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

12.1. Амралтын газар жуулчны бааз нь стандартад заасан галын аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.

12.2. Гал түймрийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зурагт самбар, аврах гарцын схем зургийг бусад үйлчилгээний мэдээлэлтэй хамт төв хаалганаас нэвтрэн орох хэсэг, зочны байр болон үйлчилгээний байруудад байрлуулна. Үүнд:

- Зочин байрлах гэр, байшингийн дотор хаалганд ойр газар;
- Гэр, байшингийн гадна нийтийн эзэмшлийн талбай дунд үйлчлүүлэгчдийн нүдэнд харагдахуйц ил газар;
- Хашаа, хайсны гадна талд иргэдэд анхааруулах зурагт самбар, санамжийг байрлуулна;
- Барилга, байшин, гэрт байрлах цахилгааны утас, залгуурын ашиглалтын шаардлага болон аюулгүй ажиллагааг бүрэн хангасан байна.



Зураг 43. Галын хорыг нүдэнд харагдахуйц газар байрлуулна (Жишээ зураг)

- 12.3. Гал түймрийн үед шаардагдах багаж хэрэгсэл. MNS 5566:2005 стандартын дагуу галын аюулаас сэргийлэх багаж хэрэгслийг хүний нүдэнд ил харагдахуйц газар тэмдэг, тэмдэглэгээ хийн байршуулна. Мөн зориулалтын жижиг галын хорыг барилгын давхруудад мөн гэр, байшин бүрд хүний нүдэнд ил харагдахаар байрлалд газраас 1 м зайтай өргөгдсөн байхаар байрлуулна.
- 12.4. Цахилгаан үүсгүүрийн түлш, шатахууныг техникийн дүрмийн дагуу хадгалах бөгөөд байгаль орчныг бохирдуулахгүй байх нөхцөлийг хангасан байна.



Зураг 44. Галын аюулаас сэргийлэх булан. (Жишээ зураг)

## Анхны тусламж

- 12.5. Үйлчлүүлэгчдэд анхан шатны эмнэлгийн тусламж үзүүлэхэд шаардагдах урьдчилан сэргийлэх хэсэгт яаралтай тусламжийн хайрцаг /шархны лент, хөвөн, бинт, чиг, эмнэлгийн зориулалтын спирт, иод, даралтын аппарат, биеийн халуун хэмжигч, бусад анхан шатны өвчин намдаах эм/ байршуулна. Зочид байрлах өрөө болон зочид хүлээн авах хэсэгт харьяалагдах дүүрэг, хорооны эмч, эмнэлэг, цагдаа, онцгой байдлын газар зэрэг шаардлагатай тусламж үзүүлэх албан газруудын утасны дугаар бүхий жагсаалтыг иргэдийн нүдэнд ил харагдахуйц газар монгол, англи хэл дээр байрлуулна.

## 13. МЭДЭЭЛЛИЙН САМБАР, АНХААРУУЛАХ ТЭМДЭГ, ТЭМДЭГЛЭГЭЭ

- 13.1. Амралтын газар, жуулчны баазын ойр орчимд байгаль орчинтой зүй зохистой харьцах тухай санамжуудыг байршуулна.

Хүснэгт 4. Мэдээллийн самбар болон анхааруулах тэмдэг (жишээ зурагтай)

 <p>Зураг 45. (Жишээ зураг)</p>	<p>Газар хагалах, ухах, тэслэх, элс, хайрга, чулуу авах, ашигт малтмал хайх, олборлохыг хориглоно</p>
 <p>Зураг 46. (Жишээ зураг)</p>	<p>Мод огтлох, бэлтгэхийг хориглоно</p>
 <p>Зураг 47. (Жишээ зураг)</p>	<p>Хог хаяхыг хориглоно</p>
 <p>Зураг 48. (Жишээ зураг)</p>	<p>Гал гаргахыг хориглоно</p>
 <p>Зураг 49. (Жишээ зураг)</p>	<p>Ариун цэврийн өрөө</p>
 <p>Зураг 50. (Жишээ зураг)</p>	<p>Жуулчны байр</p>
 <p>Зураг 51. (Жишээ зураг)</p>	<p>Чиглэл заасан тэмдэг</p>



#### 14. БОХИР УСНЫ ИНЖЕНЕРИЙН БАЙГУУЛАМЖ, ЦЭВЭРЛЭСЭН БОХИР УСАНД ТАВИХ СТАНДАРТ ШААРДЛАГА

- 14.1. Амралтын газар, жуулчны баазын үйлчилгээ эрхлэгч иргэн аж ахуйн нэгж байгууллага нь усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, усны эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн заагийг тэмдэгжүүлж, бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангаж ажиллана.
- 14.2. Бохир усны шийдэл нь байгаль орчинд сөргөөр нөлөөлөхгүй байхаар хийсэн байна.
- 14.3. Бохир усыг дахин ашиглаж, саарал ус гаргадаг технологийг нэвтрүүлнэ.
- 14.4. Бохир усны цооног нь хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй дараах стандартыг хангасан байна. Үүнд:
- MNS4943:2011 “Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир усны ерөнхий шаардлага”;
  - MNS4288:1995 “Бохир ус цэвэрлэх байгууламжуудын байршил, цэвэрлэгээний технологи түвшинд тавих үндсэн шаардлага”;
  - БНБД40-01-06 “Ариутгах татуурга, гадна сүлжээ ба байгууламж”;
  - MNS0900:2005 “Хүрээлэн буй орчин, эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдал, Ундны ус, эрүүл ахуйн шаардлага түүнд тавих хяналт”;
  - MNS5924:2015 “Нүхэн жорлон, угаадасны нүх Техникийн шаардлага”.
- 14.5. Бохир усны нүх болон цэвэршүүлэх байгууламжийг зочны байр, гэр, барилга байгууламжаас 50м-ээс багагүй зайд салхины доод чигт байрлуулна.

#### 15. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН, АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 15.1. Үйлчилгээний ажилчид нь эрхэлж буй ажлын хүрээнд холбогдох мэргэжлийг эзэмшсэн, түүнийг нотлох бичиг баримтыг ажлын байран дээр хадгална.
- 15.2. Үйлчилгээний ажилчид тухайн байгууллагыг илэрхийлсэн албан тушаал, нэр бүхий энгэрийн тэмдэг, дүрэмт хувцсаар жигдэрсэн байна.
- 15.3. Үйлчилгээний ажилчид харилцааны өндөр соёлтой байна.
- 15.4. Үйлчилгээний ажилчдыг улирал тутамд эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байна.

- 15.5. Үйлчилгээний ажилчдыг сургалтын хөтөлбөрийн дагуу 14 хоног тутамд үйлчилгээний соёлын талаар мэдлэг мэдээллээр тогтмол хангана.
- 15.6. Ажилчдад зориулсан хоолны болон цэвэрхэн, тохь тухтай амралтын өрөөтэй байна.
- 15.7. Амралтын газар жуулчны бааз нь ёс зүйн хэм хэмжээг тогтоосон дотоод журамтай байх ба үйл ажиллагааны дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлж ажиллана.

## 16. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

АМРАЛТЫН ГАЗАР, ЖУУЛЧНЫ БААЗЫН ТОХИЖИЛТ,  
ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ ШААРДЛАГА

.....оны .....сарын.....өдөр

Улаанбаатар хот

Аж ахуйн нэгжийн нэр.....

Амралтын газар, жуулчны баазын оноосон нэр.....

Хаяг, байршил.....

Холбогдох утас.....

№	Үзүүлэлт	ТИЙМ	ҮГҮЙ	Оноо (0-10)
1	“Амралтын газар, жуулчны баазад тавих ерөнхий шаардлага” MNS 6043:2019 стандартын А хавсралт дахь шалгуурыг хангасан эсэх			
2	Төлөвлөлтийн ерөнхий шаардлага хангасан эсэх			
3	Тээврийн хэрэгслийн ил зогсоолд тавигдах шаардлага <b>хангасан эсэх</b>			
4	Амралтын бүсэд тавигдах шаардлага хангасан эсэх			
5	Үзвэрийн талбайд тавигдах шаардлага хангасан эсэх			
6	Тоглоомын талбай тавигдах шаардлага хангасан эсэх			
7	Спорт талбай тавигдах шаардлага хангасан эсэх			
8	Хашаа, хайс, хашлага хангасан эсэх			
9	Явган хүний зам хангасан эсэх			
10	Гэрэлтүүлэгт тавигдах шаардлага хангасан эсэх			
11	Ногоон байгууламжид тавигдах шаардлага хангасан эсэх			
12	Зочин хүлээн авах, бүртгэх үйл ажиллагаа нь хэвийн, шаардлага хангасан эсэх			
13	Тээврийн үйлчилгээний шаардлага хангасан эсэх			
14	Харуул хамгаалалтын шаардлага хангасан эсэх			
15	Хүлээлгийн танхимын шаардлага хангасан эсэх			
16	Төлбөр тооцооны төрөл, тавигдах шаардлага хангасан эсэх			
17	Зочин байрлуулах байранд тавигдах шаардлага хангасан эсэх			

18	Хоолны газарт тавигдах шаардлага хангасан эсэх			
19	Ариун цэврийн байгууламжид тавигдах шаардлага хангасан эсэх			
20	Угаалгын газарт тавигдах шаардлага хангасан эсэх			
21	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах, түр хадгалахад тавигдах шаардлага хангасан эсэх			
22	Галын аюулгүй байдалд тавигдах шаардлага хангасан эсэх			
23	Хөдөлмөрийн аюулгүй байдалд тавигдах шаардлага хангасан эсэх			
24	Мэдээллийн самбар, анхааруулах тэмдэг, тэмдэглэгээнд тавигдах шаардлага хангасан эсэх			
25	Бохир усны инженерийн байгууламж, цэвэрлэсэн бохир усанд тавигдах стандарт шаардлага хангасан эсэх			

Дүгнэсэн:

Ажлын хэсгийн ахлагч: .....//

Гишүүд: .....//

.....//

.....//

.....//

.....//

Байгууллагыг төлөөлж байлцсан:

Амралтын газрын захирал

.....//

Амралтын газрын ажилтан

.....//











Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23-р хороо, 17100, Наадамчдын зам  
1200, Нутгийн захиргааны цогцолбор байр.



70118030, 70118040



[www.standard.ub.gov.mn](http://www.standard.ub.gov.mn)



Хотын стандарт, хяналтын газар